



**ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ
УЛСЫН ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН
ДУНДГОВЬ АЙМГИЙН
НЭГДСЭН ДҮН
/хураангуй/**

АГУУЛГА

1. ХҮН АМ	3
2.ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА	4
3. ШАШИН	5
4.ХҮН АМЫН СУУРЬШИЛ.....	5
5. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН.....	6
6. БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ	7
7.ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ.....	8
8.ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ	9
9.ИНТЕРНЭТ, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ.....	11
10.ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ	12
11. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД	15
12. СУУЦНЫ НӨХЦӨЛ.....	16

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН ТОО, ҮНДЭС, УГСАА, ХУВИАР, 2010, 2020 ОН	4
ХҮСНЭГТ 2. ГЭР, БАЙШИН, ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2019, 2020 ОН	17

ЗУРГИЙН ЖАГСААЛТ


ЗУРАГ 1. ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР	3
ЗУРАГ 2 ХҮН АМЫН ТОО	3
ЗУРАГ 3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТЛЭГТЭЙ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН.....	5
ЗУРАГ 4. ХҮН АМЫН СУУРЬШЛЫН ЕРӨНХИЙ БАЙДАЛ, 2020 ОН	6
ЗУРАГ 5. ШИЛЖИГЧДИЙН ТОО, ХУГАЦАА, НУТАГ ДЭВСГЭРЭЭР, 2020 ОН	7
ЗУРАГ 6. 10, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМ	7
ЗУРАГ 7. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН	8
ЗУРАГ 8. АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС	8
ЗУРАГ 9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН	9
ЗУРАГ 10. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, СУМ, НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	9
ЗУРАГ 11. ҮЙЛДЛИЙН ЧАДВАР, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	10
ЗУРАГ 12. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ГАР УТАС ХЭРЭГЛЭЭ, 2020	

ОН	11
ЗУРАГ 13. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВРАГА, ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, 2010, 2020 ОН.....	11
ЗУРАГ 15. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020 ОН	12
ЗУРАГ 14. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, СУМДААР	13
ЗУРАГ 16. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, СУМДААР	14
ЗУРАГ 17. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ХУВИАР, 2010, 2020 ОН.....	16
ЗУРАГ 18. ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, 2020 ОН	17
ЗУРАГ 19. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2020 ОН.....	18

1. ХҮН АМ


Дундговь аймгийн нийт хүн ам 47104, өрхийн тоо 14212 болсныг тоолж гаргалаа. Хүн амын тоо 2010-2020 оны хооронд жилд дунджаар 2.4 хувиар өссөн байна. Жилийн дундаж өсөлт өмнөх тооллогоос 4.6 пунктээр нэмэгдсэн нь хүн амын цэвэр өсөлт сүүлчийн арван жилд өндөр байсан, шилжилт хөдөлгөөн саарсантай холбоотой юм.

ЗУРАГ 1. ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР



Тооллого хоорондын хүн амын жилийн дундаж өсөлтийн дүр төрх өмнөх 10 жилтэй харьцуулвал Өндөршил сумаас бусад бүх сумд өндөр өсөлттэй гарсан байна.

ЗУРАГ 2 ДУНДГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН ТОО



Дундговь аймгийн суурин хүн ам нь насны бүтцийн хувьд ерөнхийдөө залуу хэвээр байгаа ба 0-14 насны хүүхэд 30.3 хувь, 15-64 насны хүн ам 64.4 хувь, 65, түүнээс дээш насны хүн ам 5.3 хувь эзэлж байна.

Хүйсийн харьцаа 101.0 болж өмнөх тооллогын үетэй харьцуулахад 2 пунктээр буурчээ. Мөн хүйсийн харьцаа нь манай аймгийн хувьд 45-с дээш насанд буурч байгаа боловч, 50-54 насанд өндөр, бусад насны бүлгийн хувьд буурч байгаа нь улсын дүнгээс нилээн өөр байна.

Хүн амыг насны бүтцийн хувьд таллан хувааж байгаа голч нас 27.4 болсон нь хүн амын тэн хагас нь 27.4-өөс доош, үлдсэн 50 хувь нь түүнээс дээш насныхан байна. Нийт хүн амын 0.9 хувь нь буюу 429 хүн гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж

байна.

Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгч хүн амын тоо 55.2 байна. Хүн ам зүйн ачаалал 2020 онд 2010 оноос 2.9 пунктээр буурсан байна.

Хүн ам зүйн цонх үеийг ашиглан урт хугацааны бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, ялангуяа ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарснаар улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйл эергээр нөлөөлөх юм.

2.ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА

Монгол Улсын харьяат иргэдийн үндэс, угсааны талаарх мэдээллийг өмнөх тооллогод 29 бүлгээр цуглуулж байсныг Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогоор 31 болгож өргөжүүлсэн.

ХҮСНЭГТ 1. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХАРЬААТ ИРГЭДИЙН ТОО, ҮНДЭС, УГСАА, ХУВИАР, 2010, 2020 ОН

Үндэс, угсаа	2010		2020	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	38515	100.0	46675	100.0
Халх	38439	99.8	46484	99.5
Казах	2	0.01	7	0.0
Дөрвөд	16	0.04	48	0.1
Буриад	9	0.02	30	0.1
Баяд	8	0.02	33	0.1
Дарьганга	0	0.00	15	0.0
Урианхай	3	0.01	8	0.0
Захчин	6	0.01	8	0.0
Дархад	3	0.01	8	0.0
Торгууд	0	0.00	4	0.0
Өөлд	12	0.03	15	0.0
Хотон	0	0.00	4	0.0
Мянгад	0	0.00	1	0.0
Барга	0	0.00	1	0.0
Харчин	2	0.01	1	0.0
Хотогойд	0	0.00	1	0.0
Сартуул	0	0.00	2	0.0
Хорчин	3	0.01	0	0.0
Бусад үндэс, угсаатан	11	0.03	5	0.0

1Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн тоо ороогүй


Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор Дундговь аймгийн харьяат суурин хүн амын 99.5 хувийг халхчууд эзэлж, өмнөх тооллогоос 0.3 пунктээр буурсан байна. Харин Дөрвөд, Буриад, Баяд угсаатнууд 0.3 хувийг эзэлж бусад үндэстнүүд нийт дүнгээр 0.2 хувийг эзэлж байна.

3.ШАШИН

Арван тав, түүнээс дээш насны хүн амын 69.3 хувь нь шашин шүтдэг, 30.7 хувь нь шашин шүтдэггүй гэж тоологдлоо. Шашин шүтлэгтэй хүмүүсийн 97.0 хувь нь буддын шашинтан байна.

Шашин шүтлэгийг насны бүлгээр авч үзэхэд насны бүлэг тус бүрд буддын шашинтан 96-98.2 хувийг эзэлж байгаа нь улсын дүнгээс нилээд өөр байна.


ЗУРАГ 3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТЛЭГТЭЙ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН



4.ХҮН АМЫН СУУРЬШИЛ

Хүн амын суурьшлийг харахад нийт хүн амын 26.5 хувь буюу 12412 нь аймгийн төвийн Сайнцагаан суманд, 73.5 хувь нь буюу 34286 нь хөдөө сумдад амьдарч байна. Бусад аймгуудын хот, хөдөөд амьдарч байгаа хүн амын нийт дундажтай харьцуулахад хөдөөд амьдарч байгаа хүн амын эзлэх хувийн жин харьцангуй өндөр байгаа. Энэ нь тус аймгийн хүн амын ихэнх нь хөдөөний малчид байгаатай холбоотойг харуулж байна. Учир нь аймгийн эдийн засгийн үндсэн салбар нь мал аж ахуй юм.

ЗУРАГ 4. ХҮН АМЫН СУУРЬШЛИЙН ЕРӨНХИЙ БАЙДАЛ, 2020 ОН




Дундговь аймгийн хувьд 2010 онд 1 километр квадрат нутаг дэвсгэрт 0.5 хүн ногдож байсан бол 2020 онд 0.6 болж, 0.1 пунктээр өссөн байна. 2010 оноос манай аймгийн иргэд орон нутагруугаа буюу хот суурин газраас хөдөөд шилжих хөдөлгөөн нэмэгдэж мал аж ахуй зонхилон эрхэлж байна. Хүн амын суурьшлийг сумдаар авч үзэхэд 2010 оноос хойш бүх сумдын хүн ам 11.9-54.0 хувиар өссөн байна. Хүн амын тоо нь 2010 оныхоос Өндөршил сум буурсан үзүүлэлттэй байна. Аймгийн хүн амын дундаж өсөлт 21.2 хувьтай байхад Дэлгэрцогт, Дэрэн, Цагаандэлгэр, Гурвансайхан, Өлзийт, Хулд, Луус, Дэлгэрхангай сумдууд дунджаас дээгүүр байна. Аймгийн хэмжээнд 2000-аас дээш хүн амтай сум 6, 2500-с дээш хүн амтай сум 3 байгаа нь харьцангуй өсөлттэй байна.

5. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Төрснөөс хойших аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнд оролцогч нийт суурин хүн амын 4.2 хувийг эзэлж байгаа нь өмнөх тооллоготой харьцуулахад 21 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 5. ШИЛЖИГЧДИЙН ТОО, ХУГАЦАА, НУТАГ ДЭВСГЭРЭЭР, 2020 ОН
АЙМАГ, НИЙСЛЭЛ ХООРОНД



Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2-т заасан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг энэ шилжилт хөдөлгөөнөөс улбаатай сөрөг үр дагаврууд ноцтой хөндөж байгаа тул Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2017 оны 1 дүгээр сарын 9- ний өдрийн захирамжаар хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод байнга оршин суухаар ирэх иргэдийн шилжилт хөдөлгөөнийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл зогсоосон шийдвэртэй холбоотой юм.

6. БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Арав, түүнээс дээш насны хүн амын 94.2 хувь нь ямар нэгэн боловсролын түвшин эзэмшсэн байна. Нийт боловсролтой иргэдийн дийлэнх нь буюу 28.4 хувь нь суурь боловсролтой байна.

Боловсролын түвшин өмнө жилүүдээс харьцангуй өссөн ба арав ба түүнээс дээш насны хүн амын дүнд бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь багассан байна.

ЗУРАГ 6. 10, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМ



* Нийт 10 ба түүнээс дээш насны хүн амын тоонд Монгол Улсад удаан хугацаагаар амьдарч байгаа гадаад улсын иргэдийг хамруулаагүй болно.

Дээд боловсролтой хүн амын түвшин өмнөх тооллогын дүнгээс өссөн үзүүлэлттэй гарч байна. Арав ба түүнээс дээш насны Монголын харьяат суурин хүн амын 15.7 хувь нь дээд ба түүнээс дээш боловсролтой болсон нь 2010 оны тооллогын үр дүнтэй харьцуулахад

6.4 пунктээр өссөн байна.

7.ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор нийт өрхийн тоо 2010 оноос 30.4 хувиар өссөний дотор хотын өрх 2.6 хувиар буурч, хөдөөгийн өрх 48.1 хувиар өссөн байна.

Аймгийн хэмжээнд 14.2 мянган өрх тоологдсоноос 63.3 хувь нь ам бүлээрээ байгаа өрх, 16.1 хувь нь нийлмэл ам бүлтэй, 20.1 хувь нь ганц бие, 0.4 хувь нь холимог ам бүлтэй өрх байна.

Нийлмэл ам бүлтэй өрхийн тоо хөдөөд хотоос 2.1 дахин олон байна. Ганц бие өрхийн тоо хотод өмнөх тооллогын үеийнхээс 2.2 дахин өссөнийг шилжих хөдөлгөөнтэй холбон тайлбарлаж болох юм.


ЗУРАГ 7. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН



Аймгийн хэмжээнд өрхийн ам бүлийн дундаж тоо 2010 онд 4.2 байсан бол 2020 онд 3.3 болж буурсан байна. Харин 1-2 ам бүлтэй өрхийн эзлэх хувь ихээхэн өөрчлөгджээ. Тухайлбал, 1-2 ам бүлтэй өрх аймгийн төвд 6.0 пунктээр, хөдөөд 9.4 пунктээр өмнөх тооллогын дүнгээс нэмэгдсэн байна. Энэ нь хотоос хөдөөрүү шилжих хөдөлгөөн ихэссэнтэй холбоотой байж болох юм.

Хүн амын гэрлэлтийн байдалд огт гэрлээгүй хүмүүс өмнөх тооллогоос 4.8 пунктээр өссөн, гэр бүлтэй хүмүүс 5.8 пунктээр буурсан, харин цуцалсан хүмүүс 0.6 пунктээр өссөн байна.

ЗУРАГ 8. АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС




Анхны гэрлэлтийн дундаж нас 25.6 болсон бөгөөд 2010 онтой харьцуулахад хоёр насаар хойшилсон байна. Эрэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж нас 27.2, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж нас 23.9 болсон бөгөөд 2010 онтой харьцуулахад насны ялгаа хоёр насны зөрүүтэй байгаа нь 2000-2010 онуудад нэг насны зөрүүтэй байсан бол 2010-2020 онуудад хоёр насны зөрүүтэй болж өөрчлөгдсөн байна.


8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ

Аймгийн хэмжээнд 1858 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа нь нийт суурин хүн амын 4.0 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 1040 буюу 56 хувь нь эрэгтэй, 818 буюу 44 хувь нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН



ЗУРАГ 10. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, СУМ, НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН



Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд 945 болж өмнөх тооллогоос 109 буюу 13.0 пунктээр өссөн байна. Сүүлийн жилүүдийн байгаль экологийн бохирдол болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр эхээс төрөхдөө хөгжлийн бэрхшээлтэй төрж байна гэсэн үг юм.

Харин олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өмнөх тооллогоос 132 буюу 12.6 хувиар буурсан нь аж ахуй нэгжийн аюулгүй ажиллагаа болон үйлдвэрийн осол гэмтэл, хүнд нөхцөлийн аюулгүй ажиллагаа сайжирсан байж болох юм.


Хөгжлийн бэрхшээлийг хэлбэрээр нь авч үзвэл харааны бэрхшээл 2010 оны тооллогоос 29.9 хувь, хөдөлгөөний бэрхшээл 11 хувь, ярианы бэрхшээл 45.2 сонсголын бэрхшээл 24.0 хувь, сэтгэцийн бэрхшээл 4.2 хувиар тус тус буурч, бусад бэрхшээл 74.9 хувиар өссөн байна. Нийт бэрхшээлийн дийлэнх буюу 29.3 хувийг бусад (Хавсарсан болон бусад хөгжлийн бэрхшээлийг энд оруулав), 24.7 хувийг Сэтгэц, 24,3 хувийг хөдөлгөөний бэрхшээл эзэлж байгаа бол хамгийн бага буюу 3.1 хувийг ярианы бэрхшээл эзэлж байна.

Үйлдлийн чадвар

Насны бүлгээр авч үзэхэд 20-24 насны үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийн хамгийн их хүндрэл нь ой тогтоол/ санах байгаа бол 35-54 насныхны хувьд алхах, харин 55 түүнээс насныхны хувьд алхах, өөртөө анхаарал тавих хүндрэлүүд зонхилж байна.

Үйлдлийн чадварын хүндрэлийг хүйсээр авч үзвэл хөдөлгөөний, сэтгэцийн, сонсголын чадварын хүндрэл эмэгтэйчүүдэд эрчүүдээс илүү байгаа бол эрэгтэйчүүд ярианы, харааны болон бусад хавсарсан үйлдлийн чадварын хүндрэл эмэгтэйчүүдээс илүү байна.


ЗУРАГ 11. ҮЙЛДЛИЙН ЧАДВАР, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



9.ИНТЕРНЭТ, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ


Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор зургаа ба түүнээс дээш насны нийт суурин хүн амын 86.4 хувь нь гар утас хэрэглэж байгаа бол 57.4 хувь нь интернэт хэрэглэгчид байна. Зургаа ба түүнээс дээш насны гар утас, интернэт хэрэглэгчдийн дүнд эзлэх хувь 2010 оноос харьцангуй өссөн ба гар утас хэрэглэгчид 28.1%-аар интернэт хэрэглэгчид 45.9%-аар тус тус өссөн байна.


ЗУРАГ 12. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ГАР УТАС ХЭРЭГЛЭЭ, 2020 ОН



Дэлхий нийтээр даяаршиж интернэтийн хэрэглээ маш хурдан өссөөр байгаа ба Монгол Улсад ч бас 3G болон 4G сүлжээ орж ирснээр гар утас болон байнга интернэт хэрэглэгчдийн тоо ихэссэн байна.

ЗУРАГ 13. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВРАГА, ГАР УТАС, ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ ХУВИАР, 2020 ОН





10. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Хөдөлмөрийн насны буюу арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 65.6 хувь нь ажиллах хүчинд багтаж байгаа нь 2010 оноос 0.2 пунктээр буурсан бол ажиллах хүчнээс гадуурх хүн ам (34.4%) 0.2 пунктээр өсчээ. Ерөнхийд нь үзвэл ажиллах хүчний оролцооны түвшин өнгөрсөн тооллогын үеийнхээс буурсан, харин эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо өмнөх тооллогын үеийнхээс 0.9 пунктээр буурсан байна.

Нийт хөдөлмөрийн насны хүн амд ажил эрхэлдэг хүн амын эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс 4.0 пунктээр нэмэгдэж, ажилгүй иргэд 2.7 хувийг эзэлж байна. 55 наснаас эхлэн цаашид нас ахих тутам хүмүүсийн хөдөлмөрийн чадвар буурч, 60, түүнээс дээш насны хүн амын 29.6 хувь ажиллах хүчинд хамрагдаж байгаа ч өмнөх тооллогын үеийнхээс тухайн насны хүн амын ажиллах хүчинд эзлэх хувь 7.2 пунктээр нэмэгдсэн нь эерэг үзүүлэлт байна.

ЗУРАГ 14. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020




Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо, эмэгтэйчүүдийнхээс өндөр хэвээр байна. Байршлын хувьд эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алиных нь ажиллах хүчний оролцоо хөдөөд аймгийн төвийнхөөс өндөр байна. Ялангуяа хөдөөгийн эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 73.8 хувь байгаа нь хотынхоос 14.4 пунктээр илүү үзүүлэлт юм.

Эдийн засгийн идэвх	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Ажиллах хүчний оролцооны түвшин	65.6	70.5	60.8	56.9	59.4	54.9	68.6	73.8	63.1
Ажиллах хүчнээс гадуурх хүн амын эзлэх хувь	34.4	29.5	39.2	43.1	40.6	45.1	31.4	26.2	36.9


Арван тав, түүнээс дээш настай нийт хүн амын 62.9 хувь нь ажил эрхэлж байхад энэ үзүүлэлт хөдөөд 67.1 хувь байгаа нь хөдөөгийн хүн амын дийлэнх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэгтэй холбоотой. Ялангуяа, хөдөөгийн эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт аймгийн төвийнхөөс 20.5 пунктээр өндөр байгаа нь хөдөөгийн эрэгтэйчүүдийн дийлэнх нь мал аж ахуй эрхэлж байгаагаар тайлбарлагдана.

ЗУРАГ 15. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, СУМДААР



Аймгийн хэмжээнд ажилгүйдлийн түвшин 2020 онд 4.2 хувь болж, өмнөх тооллогын үеийнхээс 10.9 пунктээр буурчээ. Ажилгүйдлийн түвшин аймагт өндөр, хөдөөд бага байна. Энэ нь нэг талаас хот суурин бараадсан шилжих хөдөлгөөн их байгаа, нөгөө талаас тэд хотод шилжин ирээд ажлын байр олох боломж муу байдагтай холбоотой.

ЗУРАГ 16. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, СУМДААР



Ажилгүй иргэдийн дотор 25-34 насны 296 залуучууд байгаа нь хамгийн их буюу нийт ажилгүй хүний 33.1 хувийг эзэлж байна. Харин 30-34 насны эрэгтэйчүүд илүү их ажилгүйдэлд өртөж байна.

Аймгийн хэмжээнд ажиллах хүчнээс гадуурх хүн ам нийтдээ 11197 байгаа нь өмнөх

тооллогоос 23.9 хувиар, үүний дотор ажиллах сонирхолгүй хүний тоо 90.3 хувиар, сургуульд сурдаг 74.1 хувиар тус тус өсчээ. Харин хөдөлмөр эрхлэх чадваргүй, гэрийн ажилтай байгаа хүмүүсийн хувь 20.8-27.7 хувиар буурсан байна.

35-44 насны хүн амын 37.9 хувь нь хөдөлмөр эрхлээгүй, гэрийн ажилтай байна. Ялангуяа 15-24 насны хүн амын 88.6 хувь нь сургуульд сурдаг нь өмнөх тооллогоос 8.9 пунктээр илүү байна.


11.ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын дүнгээр гадаадад оршин суугаа 429 иргэн тоологдож 2010 оноос 1.6 дахин өссөн бөгөөд нийт хүн амын 0.9%-ийг эзэлж байна.

Гадаадад 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа иргэдийг байнга оршин сууж байгаа улсаар нь авч үзвэл 158 буюу 36.8% нь Өмнөд Солонгос, 51 буюу 11.9% нь Япон, 42 буюу 9,8% нь Чех улсад тус тус амьдарч байна.

Гадаадад 6 сараас дээш хугацаагаар оршин сууж байгаа иргэдийн 39.6% нь суралцах 29.4% суурьших, 17,5% нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байна.

ЗУРАГ 17. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ХУВИАР, 2010, 2020 ОН



12.ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ

Дундговь аймагт Дундговь аймагт Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр нийт 14 212 өрх, орон сууцны доторх сууцыг оролцуулснаар 11221 сууцанд амьдарч байна.

ХҮСНЭГТ 2. ГЭР, БАЙШИН, ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ,
ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2019, 2020 ОН

Сууцны төрөл	Хүн байнга амьдардаг сууц			Өрхийн тоо		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БҮГД	11221	3609	7612	14212	3726	10486
Гэр	8166	1654	6512	11091	2046	9045
Байшин	3055	1955	1100	3026	1650	1376
Бусад	-	-	-	95	30	65

Байшин орон сууцны тооллогын дүнгээр нийт өрхийн 78 хувь нь монголын ард түмний уламжлалт сууц гэрт, 21.3 хувь нь байшинд, 0.7 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Гэрт амьдардаг өрхийн хувь өмнөх тооллогын үеийнхээс 4.4 пунктээр буурсан бол байшинд амьдардаг өрх 4.1 пунктээр нэмэгджээ.


ЗУРАГ 18. ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, 2020 ОН



Байшин, орон сууцны тооллогоор хүн байнга амьдардаг 10194 гэр сууц, орон сууцны байшингийн доторх сууцыг оруулбал 11221 сууц тоологдсон. Харин хүн байнга амьдардаггүй илүү гэр, зуслангийн байшин зэрэг 3379 сууц тоологджээ.

Тооллогоор хүн байнга амьдардаг сууцнаас сууцны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг амьдарч буй өрхөөс асууж цуглуулсан.

ЗУРАГ 19. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2020 ОН



Хүн байнга амьдардаг сууцыг төрлөөр авч үзвэл 80.1 хувь нь гэр сууц, 16.9 хувь нь сууцны тусдаа байшин, 0.9 хувь нь нийтийн зориулалттай орон сууцны байшин, 1.6 хувь нь бие даасан тохилог сууц, 0.4 хувь нь нийтийн байр тоологдсон байна.

Нийтийн зориулалттай 85 орон сууцны байшинд 1112 сууц тоологдсон байна.

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХАОСТ-ЫН ТҮР ТОВЧОО
2020 ОН

